



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 19 өдөр Дугаар 19.

Хэрлэн сум

ХИХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 87,6 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны А/124 дүгээр захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх баар, караокены үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосныг сунгах эсэх, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг:

2. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн тайлан, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах:

3. Тусгаарлах, ажиглах байрны бэлэн байдал, амны хаалтны нөөц бүрдүүлэх ажлын явц байдал, Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа:

4. Газрын тосны тээвэрлэлтийн бэлтгэл ажлын талаар Улсын Онцгой комисст хүргүүлсэн аймгийн ажлын хэсгийн тайлангийн хариу, Улсын Онцгой комиссоос ажлын хэсэг Дорнод аймагт ажиллах тухай, Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа:

5. Аймгийн хэмжээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүл, байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нарын үйл ажиллагааны талаар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Эрдэнэбаяр:

6. Аймгийн 2020 оны 03-06 дугаар сарын цаг агаар, хур тунадас, хуурайшилтын мэдээлэл, үүлэнд зориудаар нөлөөлөх ажлын бэлтгэлийн талаар, Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга М.Алтаннавч:

7. Аймгийн хэмжээнд мал, амьтны сэг зэмийг устгах ажлын явцын талаар, Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга Г.Баярсайхан:

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандахад,

1.1. Эрүүл мэндийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн шаардлагатай зүйлсийн жагсаалтын саналын дагуу Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн санд бэлэн байгаа даралтын аппарат, чагнуур, пульсоксиметр, мөн хүчилтөрөгч өтгөрүүлэгч 2 ширхэг 2,960,000 төгрөг, Фог машин 1 ширхэг 910,000 төгрөг, нүдний шил 100 ширхэг 400,000 төгрөг, гар халдваргүйжүүлэгч 50 литр 650,000 төгрөг, COVID 1 удаагийн түргэвчилсэн оношлуур 20 ширхэг 700.000 төгрөгөөр худалдан авах нийт 5,620,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

1.2. 20,000 ширхэг амны хаалт оёход шаардагдах материалын зардалд даавуу 1000 метр, резин 6000 метр, утас 80 ширхэг, уут 2,000 ширхэгийг худалдан авахад нийт 7,202,800 төгрөг, Улаанбаатар хотоос материал худалдан авах ажлын хэсгийн 2 гишүүний томилолт, тээврийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг,

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий, Хилийн 0275 дугаар ангийн захирагч,
хурандаа Б.Гантөгс нарт:

2.1. Улсын Онцгой комисс, Гадаад харилцааны яам, Улсын Онцгой комиссын Шуурхай штабт хилийн Эрэнцав, Ульхан боомтоор зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах тухай саналыг төслийг танилцуулахыг,

Гурав.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзоригт

3.1. Аймгийн Засаг даргын 2020 оны А/124 дүгээр захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх баар, караоке, дэн буудлын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар дугаар сарын 20-ны өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосныг 2020 оны 03 дугаар дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгах,

Дөрөв. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтүяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мал эмнэлгийн газрын дарга Ч.Аюүшмаа нарт

4.1. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажил зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж танилцуулахыг тус тус үүрэг болголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА

М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА